



**“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2026 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 01

Хэрлэн сум

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн хурлын тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН нь:

Компанийн 2026 оны бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг дэмжих тухай

ТЭМДЭГЛЭСЭН нь:

Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”, Эрчим хүчний сайдын 2026 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн а/59 дүгээр албан бичгээр ирүүлсэн удирдамжийн дагуу компанийн 2026 оны бараа, ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг хэлэлцэв.

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК нь 2026 оны ХАА-ны төлөвлөгөөг батлагдсан зардалд багтааж, 10,836,737,408.00 төгрөгийн, 105 худалдан авалтыг хийхээр төлөвлөсөн. Үүнээс: хөрөнгө оруулалт – 17, их засвар – 4, ТЗБАХ – 4, ХАБЭА – 13, бараа худалдан авалт – 32, бусад ажил үйлчилгээ – 23, СЦТССалбарын худалдан авалт – 12 байна.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Компанийн 2026 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд хэлэлцэн дэмжив.

2. “Компанийн 2026 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж, хууль тогтоомжид заасан хугацаанд холбогдох газарт хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал Ө.Жаргалсайханд даалгав.

3. Компанийн 2026 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Шилэн дансны цахим системд хуулийн хугацаанд байршуулах, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, биелэлтийг хагас бүтэн жилээр Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулахыг Гүйцэтгэх захирал Ө.Жаргалсайханд үүрэг болгов” гэжээ.

ДАРГА



О.ХУЯГЦОГТ